



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 165

Хөхбүрд

Г Сумын хэмжээнд 2025 хагас жилийн малын  
түүвэр судалгаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-ийн “в”, “Малын индексжүүлсэн даатгалын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/316 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд 2025 оны хагас жилийн малын түүвэр судалгааг 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл зохион байгуулж явуулсугай.

2. 2025 оны хагас жилийн малын түүвэр судалгааг зохион байгуулж явуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Малын түүвэр судалгааны ажлын бэлтгэлийг сайтар хангаж хуулийн дагуу ямар нэгэн зөрчилгүй, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, хяналт шалгалтын ажлыг чанартай гүйцэтгэн, түүвэр судалгаанд сонгогдсон өрх нэг бүрээр видео бичлэг хийх, цахим программд шивэх тал дээр арга зүй, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, нэгтгэлийг баг, сумын түвшинд гарган, Засаг даргад танилцуулж аймгийн Статистикийн хэлтэст 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн дотор хүргүүлэхийг Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (Д.Эрдэнэбулган)-д үүрэг болгосугай.

4. Малын түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн мэдээлэлд тулгуурлан малын индексжүүлсэн даатгалд даатгуулсан малчдад даатгалын нөхөн төлбөр олгодог тул мэдээллийг үнэн зөв цуглуулах, анхдагч мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж, системд шивэх явцад гарч болзошгүй алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлж тооллогын ажилд хариуцлагатай хандахыг багуудын тооллогын комиссын дарга нарт даалгасугай.

5. Мал тооллогын ажилд шаардагдах зардлын эрхийг журмын дагуу нээлгэж, хуваарийн дагуу, анхан шатны баримтад үндэслэн зарцуулахыг нягтлан бодогч (Л.Алимаа)-д хариуцуулсугай

6. Малын түүвэр судалгааны ажилд хариуцлагагүй хандсан албан тушаалтанд тухай бүр нь хариуцлага тооцож, судалгааг хугацаанд нь зохион байгуулж ажиллахыг Орлогч дарга (Д.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА  Т.БЯМБАДОРЖ







Засаг даргын 10.95-оны 06 дугаар  
сарын 02 ны өдрийн 4/65 дугаар  
захирамжийн хавсралт

МАЛЫН ХАГАС ЖИЛИЙН ТҮҮВЭР СУДАЛГААГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Д.Эрдэнэбулган (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Т.Төрбат (Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Авид (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)

М.Сэр-Од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)

Ё.Дамдинпүрэв (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Л.Алимаа (Нягтлан бодогч)

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_